БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР

"ДУНДГОВЬ АЙМГИЙН 15 СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨЛӨЛ, ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДЛЫГ ТУСГАН ШИНЭЭР БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ" ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 09-р сарын 10-ны өдөр Дугаар: 1 Мандалговь хот

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар, даалгавар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	1. Газар, байгалийн нөөц ашиглалт, хамгаалалтыг хамгийн үр дүнтэй, зөв зохистой байлгах нөхцөлийг бүрдүүлсэн, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тусгахад тухайн сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын гол үндэслэл оршино; 2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт; 3. Монгол улсын Газрын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах", 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан Газар зохион байгуулалтын цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 4. Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" (Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол); 5. ГЗБГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2019 оны 07 сарын 03-ны өдрийн А/134 дугаар тушаалаар батлагдсан "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй"; 6. 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 92 дугаар тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалт хийх журам"; 7. Монгол Улсын Их хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг төлөвлөгөөнд тусгах;
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан газар, байгалийн нөхцөл, нөөц, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, орон нутгийн уламжлалт онцлогт нийцүүлэн олон төрөлт газар ашиглалтыг хөгжүүлэх, газрын нөөцийн үр өгөөж, бүтээмжийг дээшлүүлж урт хугацаанд тогтвортой ашиглахын зэрэгцээ экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг дэмжсэн дунд хугацаанд хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэл, эмзэг байдлыг тусган боловсруулахад оршино.
3.	Баримтлах зарчим	Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад дараах зарчмуудыг баримталсан байна. 1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэх;

		2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, улс, орон нутгийн хөгжлийн бодлого, хэтийн зорилт, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн иргэд олон нийтийн оролцоог хангасан хэрэгжихүйц, зорилго, зорилт, хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөх; 3. Төлөвлөгөөний зураг төсөл түүнтэй холбоотой бусад суурь судалгааны мэдээллүүд нь геодезийн байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд зохиогдсон байх. 4. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын улмаас үүсэх эрсдэл, цар хүрээ, учруулах нөлөөлөлд тохиромжтой хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх 5. Хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, эмзэг байдлыг даван туулах, дасан зохиоцох онцлогуудыг уялдуулах 6. Уур амьсгалын эмзэг байдалд тулгуурласан газар ашиглалт хамгааллын арга хэмжээ, нийгмийн хамгаалал, жендерийн тэгш байдлыг хангах арга хэмжээг тусган төлөвлөгөөг боловсруулна.
4.	Ажлын хамрах хүрээ	Дундговь аймгийн сумын нийт нутаг дэвсгэр 7469032 га
5.	Ажил гүйцэтгэх хугацаа	Эхлэх хугацаа: 2024 оны ..... сарын ..... өдөр Дуусах хугацаа: 2024 оны.....сарын..... өдөр
6.	Ажлын иж бүрдэл	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний иж бүрдэлд дараах бичиг баримт багтана. Үүнд: 1. Бэлтгэл болон хээрийн судалгааны тайлан /тус бүр/- 3 боть 2. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайлбар бичиг – 3 боть 3. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө - 3 боть 4. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг, газар, байгалийн нөхцөл, нөөцийн судалгаа болон төлөвлөлтийн зургийн тоон мэдээлэл, зургийн эхийг бэлтгэсэн прожект (Shapefile, MXD)-3 DVD 5. Суурин судалгаа болон хээрийн судалгааны ажилд ашиглагдсан судалгааны зураг болон баримт материалууд 6. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем /www.egazar.gov.mn/-д байршуулж баталгаажуулсан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайлан, зураг төсөл -1 төсөл
7.	Гүйцэтгэх ажил	Сумдын нутаг дэвсгэрийн хегжлийн телевлегеег боловсруулахдаа дараах асуудлуудыг онцгойлон тусгана. Үүнд: - ГЗБГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2019 оны А/134 дугээр тушаалаар батлагдсан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргазүй"-г уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан сайжруулж боловсруулсан ШИНЭЧИЛСЭН АРГА ЗҮЙН дагуу гүйцэтгэх; - 15 сумын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, хандлага, эмзэг байдал, эрсдэл, хөдөө аж ахуйн болон усны салбарын дасан зохицохуйн онцлогийг тогтоох үнэлгээ хийн үр дүнд үндэслэн сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах; - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хөгжлийн төлөвлөлтийг хийхдээ “Сумдын өрсөлдөх чадвар” буюу

		тухайн нутаг дэвсгэрийн экосистемийн өөрчлөлт, биологийн олон янз байдал зэрэг байгалийн нөөцийн онцлог, нийгэм-эдийн засаг, жендер, хөдөөгийн малчдын хөгжлийн онцлог, түүний нөлөөллийг тусгах; - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг бууруулахад чиглэсэн нэн тэргүүнд авах арга хэмжээг ногоон хөгжлийн үндсэн зарчим, "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан сумдын түвшинд төлөвлөн тусгах; - Сумдын малчдын байгууллагын оролцоотойгоор гүйцэтгэх байгалийн нөөцийн хамтын менежменттэй холбоотой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх газрын байршил, талбайн хэмжээ зэргийг уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, эмзэг байдлыг даван туулах, дасан зохицох онцлогуудтай уялдуулан тодорхойлон зураглаж, төлөвлөгөөнд оруулах. **Гүйцэтгэх ажил дараах үе шаттай байна.** **1. Бэлтгэл үе шат:** **Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг судлах, уялдуулах:** Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа улс, бүс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийвчлан тодруулж түүнд нийцүүлэн, сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд шууд тусгаж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. **Хөгжлийн бодлогын баримт бичиг, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тайланг судлах, уялдуулах:** Улс, бүс, аймаг, сумын чанартай бодлогын баримт бичгийг судлаж тухайн сумтай холбоотой бодлого, арга хэмжээ, үйл ажиллагааны жагсаалтыг гаргана. Ялангуяа тухайн суманд хэрэгжиж буй, зохих эрх бүхий этгээдээр албан ёсоор батлагдсан хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн баримт бичгийг сайтар судлаж тэдгээрийг хэрэгжүүлэх орон зайн болон газар, байгалийн нөөцийн чадавхийн боломжийг үнэлж дүгнэн, бодит шийдлийг тодорхойлж түүнтэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах. Усны нөөцийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө, ойн менежмент, бэлчээрийн менежмент эсвэл тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, түүнчлэн холбоос нутаг, нүүдлийн зүйлийн талаар хийсэн судалгааны үр дүнд тогтоосон газар нутгууд гэх мэт тусгай салбарын менежментийн төлөвлөгөөг судалж төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, уялдуулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлох. **Байгалийн нөөц, нөхцөл, төрх байдлыг судлах:** Улс, аймаг, сумын нутаг дэвсгэр дээр хийгдэж байсан бүх төрлийн байгалийн нөөц, нөхцөл, төрх байдлын судалгааны ажлыг судалж, нэгтгэн газар зүйн мэдээллийн системийг ашиглаж, тоон хэлбэрт оруулж, сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэнэ. Сэдэвчилсэн зураг хийхдээ "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй"-д заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зураглана. **2. Газар ашиглалтын судалгаа** Сумын нутаг дэвсгэрт өмнө хийгдэж байсан газар ашиглалттай холбоотой судалгааны тайлан, газрын нэгдмэл сангийн тайлан, газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэл, бусад мэдээллийг

		цуглуулж, хөдөө аж ахуй, тусгай хэрэгцээ, ой, усны сан бүхий газар, зам шугам сүлжээний газар ашиглалтыг зориулалт бүрээр 1:100000, 1:50000, 1:25000, 1:10000 масштаб, хот суурингийн газар, аялал жуулчлалын газар, уул уурхайн газар, хөдөө аж ахуйн суурин газарт 1:10000, 1:5000, 1:1000 масштаб зэрэг харгалзах хамгийн том масштабтайгаар сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэнэ. **Нийгэм эдийн засгийн мэдээлэл бүрдүүлэх:** Хээрийн судалгааны үе шатанд хийгдэх нийгэм, эдийн засгийн судалгаанд ашиглагдах мэдээг байрлалд суурилсан "Нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан" болон холбогдох байгууллагуудаас авч, цуглуулна. **Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх:** Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүй"-н дагуу тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу том масштабын шаардлагад нийцсэн мэдээллийн нарийвчлалыг хангаж, хүчин зүйлийн шалгуур үзүүлэлтийг тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн сонгож газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг дээрх арга зүйд орсон 8 ангиллын дагуу хийнэ. **Газар ашиглалтын хэрэгцээт байдлыг тодорхойлох:** Сумын нийгэм эдийн засгийн нөхцөл нөөц, хэрэгцээ шаардлагад үндэслэн газар ашиглалтын хэрэгцээт байдлыг дараах төрлүүдээр тодорхойлно. - Хот суурин газрын хэрэгцээ - Нийгмийн дэд бүтцийн хэрэгцээ, (сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёл, урлаг гэх мэт олон нийтийн байгууллага, амины болон нийтийн орон сууц, ажлын байрны хэрэгцээ шаардлага (салбар бүрээр), ногоон байгууламж, эмийн сан, банк, халуун ус, сүм хийд, цэвэрлэх байгууламж, хог, хаягдлын цэг гэх мэт үйлчилгээний бусад газар) - Зам шугам сүлжээний газрын хэрэгцээ; Инженерийн дэд бүтцийн хүрэлцээ хангамж (цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус дамжуулах барилга, байгууламж, ариутгах татуурга) - Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, хүн амын ундны усны хэрэгцээ - Хадлан, малын тэжээл, хадлангийн газрын хэрэгцээ - Тариалангийн газрын хэрэгцээ - Худаг, усан сангийн хэрэгцээ **Сумын хөгжлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх:** Сумын нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтэц, газрын харилцааны чиглэлүүдээр СВОТ(SWOT) шинжилгээ буюу гадаад, дотоод орчны судалгаа болон ПЭСТЭЛ (PESTEL) болон асуудлын шинжилгээний аргуудыг хослуулан хэрэглэж одоогийн байдал, тулгамдаж буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх нөөц чадавх боломжуудыг тодорхойлно. 1. Хээрийн судалгаа, санал, хэлэцүүлэг: Хээрийн судалгаанд ашиглагдах дараах тоног төхөөрөмж, програм хангамж, хэвлэмэл хуудсыг бэлтгэнэ. **Хээрийн хэмжилт судалгаа, санал асуулга хэлэлцүүлэг:** Хээрийн судалгааны үе шатанд дөрвөн үндсэн ажлыг гүйцэтгэнэ. Үүнд: - Хил зааг, байршил, хэмжээг тогтоож хэмжилт зураглал хийх

		- Сумын статистик мэдээ цуглуулах - Салбар дундын, жендэрийн мэдрэмжтэй, олон талын оролцоог хангасан байдлаар иргэд, олон нийтээс санал авах - Газрын чанарыг тодорхойлох - Тохиромжтой байдлын үнэлгээг газар дээр нь тулгах **Хил зааг тогтоож зураглалыг хийх:** MNS 6317: 2012, MNS 6316:2012 стандартыг ашиглана. Хэмжилт судалгаа зураглал нь сумын нийт нутаг дэвсгэрийг хамарсан газар ашиглалтын төрлүүд түүний хил зааг, байршил тогтоож хэмжилт зураглал хийнэ. Зүй ёсны эрхийн зориулалтын төрлүүд болон газар, байгалийн нөөцийн тархац, хэмжээг төрөл бүрээр нь газар дээр нь иргэдтэй хамтран тогтоож зураглах. Ялангуяа бэлчээрийн улирлын хуваарь, нийтээр болон гэрээгээр ашиглуулах бэлчээр, малчдын өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, худаг уст цэг болон бэлчээр ашиглалтын бусад төрлийг хэмжиж зураглан, тэдгээрт байрших малын тоог тухайн оны Мал тооллогын А дансны мэдээллээс авч хүснэгтийн атрибут мэдээлэлтэй холбож Shp файл үүсгэнэ. **Статистик мэдээ цуглуулах:** Бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн хүснэгтэн мэдээний загвараар сумын статистикийн мэдээллээс нийгэм эдийн засгийн холбоотой шаардагдах тоон мэдээллийг авна. **Иргэдээс санал авах оролцоог хангах:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцоог хангах үүднээс малчин өрх, тариалан эрхлэгчдийн 45%, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 25%, сумын ЗДТГ-ын ажилтнуудын 70%-ийг судалгаанд хамруулахаар тооцон судалгаа хийнэ. Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг, зорилтот бүлгийн уулзалтуудыг хийж сумын эдийн засгийн үндсэн чиглэлийг гаргана. Үүнд: - Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломж, сонирхол үр ашгийн тооцоо - Малын үүлдэр угсааг сайжруулах арга зам, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж гарц - Сумын хэмжээнд чадварлаг боловсон хүчнийг хэрхэн бэлтгэх арга зам - Хүн амын шилжих хөдөлгөөн сумын эдийн засагт хэрхэн нөлөөлөх болон газар ашиглалтын шинэ хэлбэрээр эдийн засгийг тэлэх зэргээр бусад асуудлууд орно. Иргэдийн санал бодлыг нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд тусгуулахдаа ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг тодорхойлох нь сумын тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой. Иймээс төлөвлөлтөнд иргэдийн оролцоог хангах үүднээс дараах аргуудыг хэрэглэнэ. Үүнд: Нүүр тулсан уулзалт, уулзалт ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, асуулгын судалгаа, зорилтот бүлгийн саналаар хийгдсэн зураглал, хэмжилт болон сумын онцлогыг харуулах SWOT дүн шинжилгээ болон PESTEL улс төр, нийгэм эдийн засаг, технологи, хууль эрх зүй, байгаль орчны нөлөөллийн хүчин зүйлийг тодорхойлох шинжилгээг хийнэ. **Тохиромжтой байдлын үнэлгээг газар дээр тулгах:** Бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн тохиромжтой байдлын үнэлгээний таарцыг газар дээр тулгаж үзнэ.

		Газрын чанарыг тодорхойлох: Газрын чанарыг тодорхойлдог арга, стандартыг ашиглан газрын чанарын өөрчлөлт, доройтлыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд: - Бэлчээрийн ургац, зүйлийн бүрэлдэхүүн, даац багтаамж - Бэлчээрийн экологийн чадавх - Бэлчээрийн төлөв байдал өөрчлөлт талхлагдал - Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол - Тариалангийн газрын элэгдэл эвдрэл, ашиглалт - Газрын гадаргын элэгдэл эвдрэл, бохирдол - Бэлчээрийн фото мониторингийн судалгаанд үндэслэж "Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загвар"-ыг ашиглан бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох. Бэлчээрийн төлөв байдлыг сэргэх чадавхийн ангилалаар байршлын зураг гаргаж талбайн хэмжээг тодорхойлох - Тохиромжтой байдлын үнэлгээгээр тариаланд тохиромжтой үр дүн гарсан байршлуудаас хөрсний дээж авч төлөв, байдал чанарыг тодорхойлох **Газрын доройтлын зэргийг үнэлэх, зураглах:** - ХАА-н газрын доройтол /хөрсний элэгдэл, ялзмаг болон шим тэжээлийн алдагдал/, бэлчээрийн даац хэтрэлт, уул уурхайн сөрөг нөлөөллийн тооцоо судалгаа, газрын байршил талбайн хэмжээг тодорхойлох. - Тариалангийн талбайн салхи, усны элэгдэл, үржил шимийн алдагдал тодорхойлох - Бэлчээрийн газрын өөрчлөлтийг үнэлэх фото мониторингийн судалгааны мэдээлэлд үндэслэн бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх. - "Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал өөрчлөлтийн загвар"-ыг ашиглан бэлчээрийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох. - Зам шугам сүлжээний газрын зэрлэг амьтны байршил, шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, малчдын нүүдэлд учруулж буй бэрхшээлийн судалгаа, зураг. - Газар ашиглалтаас усны нөөцийн хомсдол, бохирдолд үзүүлж буй сөрөг нөлөөллийн судалгаа зураг **3. Материал боловсруулалтын үе шат** Энэ үе шатанд хээрийн судалгаагаар олж авсан бүх мэдээллийг нэгтгэн боловсруулж зохих дүгнэлтийг хийж төлөвлөгөөний төслийг гаргана. Төлөвлөгөө нь дараах төрлүүдээр хийгдэнэ. Үүнд: **Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө:** Холбогдох хууль журам, дүрмээр тогтоосон хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсүүдийн талаар хийсэн судалгаануудыг үндэслэж /хэрвээ хийгдээгүй бол шинээр хамгаалалтын бүсүүдийг тогтоож зураглах/ түүн дотор дагаж мөрдөх дэглэмийг сахиулах арга хэмжээ болон газар, байгалийн нөөцийг ашиглах зориулалт хэмжээг тус тус тодорхой зааж өгч төлөвлөнө. - Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн төрөл дэглэм хэмжээ - Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсийн төрөл дэглэм - Шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсийн төрөл, хэмжээ - Авто замын хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм хэмжээ

		Хөдөө аж ахуйн газарт: - ХАА-н үйлдвэрлэлийн төлөвлөгөө - Бэлчээрийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сумын стратеги төлөвлөгөө **Бэлчээрийн газрын менежментийн төлөвлөгөө:** - Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бүс - Өвөлжөө хаваржааны бүс - Зуслан намаржааны бүс - Бэлчээр ашиглалтын улирлын хуваарийн төлөвлөгөө, түүнийг ашиглах цаг хугацаа болон ашиглалтын үргэлжлэх хугацаа - Сумын хэмжээнд төлөвлөлтийн хугацаан дахь сүргийн эргэлт, зохистой, бүтцийг сум, баг, улирлын бэлчээр тус бүрээр тооцох; - Бэлчээр ашиглагчдын хэсгийн төлөвлөгөө - Өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх төлөвлөгөө; /нэгж талбар бүрээр/ - Бэлчээр ашиглагчдын хэсэг бүлэгт бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах төлөвлөгөө - Отрын нөөц бэлчээрийн газрын ашиглалт хамгаалалтын төлөвлөгөө - Усжуулах бэлчээрийн төлөвлөгөө - Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтөөс хамаарсан сэлгэх, өнжөөж амраах, нөхөн сэргээх болон бусад менежментийн арга хэмжээний төлөвлөгөө - Эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс, газрын төлөвлөгөө - Мал тууварлах, бэлчээх зорилгоор бусдын газрыг дамжин өнгөрөх сервитут эрх тогтоох бэлчээрийн зурвас газрын хэмжээ, байршил хил зааг - Төлөвлөлтийн хугацааны хүн ам болон газрын нөөц, чадавхи, мал сүргийн эргэлттэй уялдуулан сумын хэмжээний мах, сүү, ноос, ноолуур, арьс шир, дайвар бүтээгдэхүүн гэх мэт мал аж, ахуйн бүтээгдэхүүн, таваарын үйлдвэрлэлийн хэмжээг тооцоолж, тэдгээрийг хадгалах, боловсруулах үйлдвэр, борлуулах схемийг төлөвлөж, аймгийн түвшинд сумын үүрэг оролцоо, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох - Цаашид доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, бэлчээр ашиглалтыг, бэлчээрийн сэргэх чадавхид суурилан ашиглалтын зөвлөмж боловсруулах, бэлчээрийг сайжруулах, хамгаалах арга хэмжээг төлөвлөх; - Даацаас хэтэрсэн малыг зах зээлд нийлүүлэх хэтийн төлвийг тооцох, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах хөдөө аж ахуйн үйлдвэр байгуулах газрын байршил, талбайн хэмжээг төлөвлөх - Мал амьтны гоц халдварт өвчин гарсан голомтот цэг, байршлыг тусгайлан бүртгэлжүүлж тухайн газарт үйл ажиллагаа явуулахыг хориглож хязгаарлах - Сум дундын болон сумын отрын нөөц бэлчээрийг тодорхойлж, газрын байршил, талбайн хэмжээг тодорхойлох **Хадлангийн газрын төлөвлөгөө:** - Хадланд тохиромжтой бэлчээрийн газрыг тодорхойлох - Хөцөөлсөн хадлан /хашаалах/ - Бэлчээрийн даацад тохирсон малын тоо, толгой, тэдгээрт шаардлагатай тэжээлийн нөөцөд нийцүүлэн аймаг, сумын

		чанартай хадлангийн талбайг төлөвлөж зураглах - Хадлангийн зориулалтаар ашиглаж байгаа болон цаашид ашиглах газрын байршил, талбайн хэмжээг төлөвлөх **Тариалангийн газрын төлөвлөгөө:** /Таримал ургамлын төрлүүдээр ялгаж төлөвлөнө./ - Жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал тариалах бүс - Төмс, хүнсний ногоо тариалах бүс - Үр тариа тариалах бүс - Атаршсан болон шинээр эргэлтэнд оруулах тариалангийн газар төлөвлөх; - Нэмж тариалан эрхлэх боломжтой тариалангийн газрын төлөвлөлт; - Тариалангийн талбайд шаардлагатай бол биологийн олон янз байдлын холбоос нутгийг гаргаж төлөвлөнө - Тариалангийн талбайг салхины элэгдлээс хамгаалах ойн зурвас байгуулах байршлыг тодорхойлж төлөвлөх **Хот тосгон бусад суурин газрын төлөвлөгөө:** - Хот тосгон, бусад суурины газрын газар ашиглалтын байдлыг үнэлж, одоо байгаа хот тосгон, бусад суурины эдэлбэр газрыг тэлэх, өөрчлөх байршил, хэмжээг төлөвлөлтийн хугацааны хүн амын өсөлт, хэрэгцээт байдлын үнэлгээ болон орон нутгийн саналд үндэслэн төлөвлөх - Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг үнэлэх, шаардлага хангахгүй, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжиж дууссан эсвэл зохиогдоогүй нөхцөлд хот суурины функциональ бүсчлэлийг Хот байгуулалтын тухай хууль, "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04 дагуу орон нутгийн онцлогт нийцүүлэн тогтоож, төлөвлөх /төлөвлөх эсэхийг захиалагчтай зөвшилцөх/ - Сумын төвийн хот суурины эдэлбэр газарт доторх зам, шугам сүлжээний газрыг, хамгаалалтын бүс, зурвас газрын хамт төлөвлөх - Сумын төвийн хот суурины эдэлбэр газрын хот тосгон, бусад суурины эдэлбэр газрыг тэлэх, өөрчлөх байршилд иргэнд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ, байршлийг нэгж талбар бүрээр зураглаж, зам, шугам сүлжээний газар, хамгаалалтын бүс, зурвас газрын хамт төлөвлөх - Багийн төвийн суурин газрын төлөвлөгөө - Уурхайн суурьшлын газрын төлөвлөгөө - Аялал жуулчлал хөгжүүлэх газрын байршил, төлөвлөгөө - Гал түймэр, үер ус, газар хөдлөлт гэх мэт байгалийн гамшигт өртөгдөх эрсдэлтэй газарт авах эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх байршил, хэмжээг төлөвлөх - Өмчүүлэх, эзэмшүүлэх газрын нөөцийг тогтоох, шинээр суурьшил үүсгэх газарт иргэнд эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын төлөвлөлтийг нэгж талбар бүрээр хийх **Аялал-рекреацийн нөөц бүхий газрын төлөвлөлт:** - Аялал-рекреацийн ерөнхий үнэлгээ төлөвлөх - Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан бүсийн хэмжээ, байршлыг тогтоон зураглах. - Экологийн аялал /экотуризм/-ын бүс нутгийг хөгжүүлэх

		төлөвлөлт. - Түүхи соёлын дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс нутгийн төлөвлөлт. **Хамгаалалтын бүсийн газар зохион байгуулалтын төлөвлөлт:** - Хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм, хэмжээг төлөвлөх. **Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийн төлөвлөлт:** - Зүй ёсны эрхийг төлөвлөх. **Усан сангийн газрын төлөвлөгөө:** - Гадаргын усны хамгаалалтын бүсийг тогтоох, зураглах - Усжуулах бэлчээр, нутгийн төлөвлөгөө - Хөв цөөрөм байгуулах боломжтой газрын төлөвлөгөө - Усан хангамжийн ирээдүйтэй талбайн цэгийн байршлыг тогтоох, газрын доорх усны орд бүхий газруудыг байршил нутгаар төлөвлөгөөнд тусгасан байх - Сум суурин газарт хүн амын үндны цэвэр усны нэгдсэн сан, цэвэрлэх байгууламж баригдах газрын асуудлыг төлөвлөгөөнд тусгах **Зам шугам сүлжээний газрын төлөвлөгөө:** - Шинээр барих хатуу хучилттай авто замын төлөвлөгөө - Шинээр барих цахилгаан болон холбооны шугамын төлөвлөгөө - Мал, зэрлэг амьтны экологийн гарцын төлөвлөгөө **Ойн сан бүхий газрын төлөвлөгөө:** - Ойн ашиглалт, хамгаалалтын бүсийн төлөвлөгөө - Ойн нөхөрлөлд эзэмшүүлэх газрын төлөвлөгөө - Мод үржүүлэх газрын төлөвлөгөө - Ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ төлөвлөгөө **Тусгай хэрэгцээний газрын төлөвлөгөө:** - Улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрын байршил, хэмжээ, үндэслэл - Хадгалан хамгаалах буюу орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөгөө - Шинжлэх ухаан сорилт, туршилтын газрын төлөвлөгөө - Байгалийн нөөц, баялаг ашиглах зүй ёсны эрхийн төрлүүдийг тодорхойлох - Одоо байгаа Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын дотоодын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах **Газрын нэгдмэл сангийн экспликацийг гаргах:** - Төлөвлөлтийн үр дүнд газрын нэгдмэл санд орох өөрчлөлтийг харуулсан экспликацийг гаргах **Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах:** Төлөвлөгөөний шийдэл, арга хэмжээ, үйл ажиллагаа бүрийн хүрэх үр дүн, холбогдох хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах төсөв зардал түүний эх үүсвэр, оролцогч талууд тэдгээрийн үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлж “Сумын нутаг дэвсгэрийн

		төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулах. **Багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, санал авах:** Энэ үе шатанд боловсруулсан төлөвлөгөө болон нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнг хөгжлийн чиг хандлага болгон багийн иргэдээр хэлэлцүүлэн санал авч төлөвлөгөөнд тусгах ажил хийгдэнэ. **Төлөвлөгөөний төсөлд санал авах, холбогдох байгууллагуудаар хянуулж мэргэжлийн дүгнэлт гаргуулах** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийн төсөл, төлөвлөлтийн зургуудыг А0 хэмжээгээр хэвлэн ИТХ-аар хэлэлцүүлэхийн өмнө сумын засаг даргын тамгын газрын байранд олон нийтэд харагдахуйц газарт, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын газрын мэдээллийн сангийн веб системд /egazar.gov.mn/ 30-аас доошгүй хоногийн хугацаанд байршуулж иргэд, олон нийтээс санал авна. Мөн энэ хугацаанд Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон сумын газрын даамал нь нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн судалгаа, тодруулалт, уулзалт, ярилцлага, иргэд олон нийтийн санал, асуулга, бүлгийн хэлэлцүүлгийн шат, төлөвлөлтийн үе шат, сум, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулсан байдалд хамтарсан дүгнэлт гаргаж гүйцэтгэгчид албан бичгээр хүргүүлнэ. Гүйцэтгэгч уг дүгнэлтийг төлөвлөгөөний төслийн хамт Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн мэргэжлийн дүгнэлт гаргуулна. **Сумын ИТХ-аар баталгаажуулах:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн саналыг тусган дүгнэлт гаргуулан, эцсийн байдлаар сумын ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгнө. **Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг холбогдох байгуулагад хүлээлгэн өгөх:** "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй"-н 9 дэх хэсэгт заасны дагуу төлөвлөгөөний иж бүрдлийг ханган орон нутаг, төрийн захиргааны байгууллагуудад хүлээлгэн өгнө.
8.	Гүйцэтгэх ажлын үе шат	ГЗБГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар батлагдсан "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргазүй"-г үүр амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан сайжруулж боловсруулсан ШИНЭЧИЛСЭН АРГА ЗҮЙН дагуу гүйцэтгэх. Үүнд: 1. Бэлтгэл ажил (Хүрээлэн буй орчин, байгалийн нөхцөл, нөөц, төлөв байдал, нийгэм, эдийн засаг, газар ашиглалтын мэдээллийн сан бүрдүүлэх, хээрийн судалгаагаар тодруулах шаардлагатай мэдээллүүдийг тодорхойлох) 2. Хээрийн судалгаа (Олон нийтийн оролцоотой судалгаа, хэмжилт зураглал, тодруулалтын ажил гүйцэтгэнэ) 3. Судалгааны үр дүнг нэгтгэх, төлөвлөгөөний эхний хувилбар /төсөл/-ыг боловсруулах (Тухайн сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, нийгэм эдийн засгийн хэрэгцээт байдлын үнэлгээний үр дүн, олон нийтийн санал, санаачлага болон бусад судалгаа тодруулалтын үр дүнд дүн шинжилгээ хийж төлөвлөлтийн хувилбарыг боловсруулна) 4. Багийн иргэдийн Нийтийн хурлаар төслийг хэлэлцүүлэх 5. Төлөвлөгөөний сүүлийн хувилбар (төсөл)-ыг боловсруулах

		/www.egazar.gov.mn байршуулах/ 6. СНДХТ-ний төслийг Сумын Иргэдийн Төлөөлөгчдөд хүргүүлж, санал авах 7. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын саналыг тусган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж, дүгнэлт гаргуулах. 8. Дүгнэлтийн дагуу засварлаж, Сумын Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаар хэлэлцүүлж, дхрбатлуулах, холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх. 9. Төлөвлөгөөний үе шат бүр дэх төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг ГЗБГЗЗГ(хуучин нэрээр)-ын даргын 2020 оны А/40 тоот тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын дагуу "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-ийг ашиглан гүйцэтгэнэ.
	Техникийн шаардлага	1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 123 дугаар тогтоолоор баталсан "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам", 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам" 2. Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсаны дагуу 3. "Геодезийн байрлалын сүлжээг WGS-84 солбицол, өндрийн сүлжээг Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд байгуулж, зураглалыг UTM тусгагт зохионо. 4. ГЗБГЗЗГ(хуучин нэрээр)-ын даргын 2019 оны А/134 дугаар тушаалаар батлагдсан 5. "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй" 6. ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан 7. "Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ боловсруулах аргазүй 8. "Үндэсний стандарт шинээр батлах тухай "Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны А/36 дугаар тушаал 9. Төлөвлөлтийн зургийг Монгол улсын стандарт "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:1000, 1:2000, 1:5000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6316:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:25000, 1:50000, 1:10000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6317:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:500000, 1:1000000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6315:2012 болон атрибут мэдээллийн тоон өгөгдлийн стандарт 10. ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2016 оны А/206 дугаартушаалаар батлагдсан "Улс, бүс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зургийн тоон мэдээлэл боловсруулах заавар" 11. ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/224 дугаар тушаалаар батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам" 12. ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2015 оны 01 дүгээр сарын 22-ны А/22 дугаар тушаалаар батлагдсан "Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах түр заавар" 13. Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Газрынтөлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"

10.	Ажлын хяналт шалгалт	1. Аймгийн ГХБХБГ болон сумын Газрын даамал нь "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах" ажлын захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэнэ. 2. Захилагчийн техникийн хяналтын зардал нь нийт зардалын 5 хувь байна. 3. ГЗБГЗЗЕГ-нь сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг улс, бүсийн чанартай хөгжлийн бодлого төлөвлөлтийн болон улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байдал, төлөвлөгөөг холбогдох журам, заавар аргачлалын шаардлагад нийцсэн байдал, төлөвлөлтийн болон суурь судалгааны газар зүйн мэдээллийн санг тоон хэлбэрээр үүсгэсэн байдалд хяналт хийж, мэргэжлийн дүгнэлт гаргана. 4. Аймгийн ГХБХБГ болон Газрын даамал нь гүйцэтгэгч байгууллага сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад аймаг, сумын эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль хамгааллын салбаруудын дэд хөтөлбөр, төлөвлөгөө, стратегитэй уялдуулах, хэлэлцүүлэг хийх ажлыг гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулах үе шатны бүхий л үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ГЗБЗЗЕГ-т ажлын явцыг тайлагнаж ажиллана. Ажлын нийт явцыг үнэлсэн дүгнэлт гаргаж, төлөвлөгөөний төслийн хамт иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулна. 5. Орон нутаг дахь бүхий л салбарын төрийн байгууллагууд, иргэдийн байгууллага /иргэдийн Төлөөлөгчдийн хурал, иргэдийн Нийтийн хурал, төрийн бус байгууллага/, иргэдээс санал авч, мэдээлэл танилцуулга хийсэн байна. 6. Захиалагчийн дүгнэлтийг үндэслэн "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө"-ний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж төлөвлөгөөг батлуулна.
11	Хүлээлгэн өгөх материал	Батлагдсан төлөвлөгөөний баримт, материал иж бүрдэл дараах баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд: 1. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол 2. Газар, байгалийн нөхцөл, нөөцийн тайлан 3. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайлан, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 4. Shapefile эсхүл geodatabase прожект файлын хамт 5. ГЗБГЗЗЕГ-ын албан бичгээр өгсөн техникийн дүгнэлт 6. "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем" болон www.egazar.gov.mn-д цахим хэлбэрээр байршуулсан Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайлан, тоон зураг, баталсан шийдвэр, хянасан дүгнэлт Батлагдсан төлөвлөгөөний баримт, материал иж бүрдлийг 1 хувь бэлтгэн хэвлэмэл болон тоон хэлбэрээр хүлээлгэн өгнө. 1. Сумын Засаг даргын тамгын газарт 1 хувь 2. Сумын Газрын даамалд 1 хувь 3. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 1 хувь 4. ГЗБГЗЗЕГ-ын Архив, мэдээллийн хэлтэст 1 хувь (Тайлан, мэдээллийг хүлээлгэж өгөхдөө ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам", ГЗБГЗЗЕГ-ын даргын 2020 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын дагуу "Газар

		зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-ийн шаардлагыг тус тус баримтална.
12.	Захиалагч байгууллага	1. Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар 2. Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
13.	Гүйцэтгэгч байгууллага	Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд байна.
14.	Санхүүжилт, эх үүсвэр	• Орон нутгийн хөгжлийн сан • Захиалагчийн техникийн хяналтын зардал 5 хувь байна. • Бэлтгэл үе шат, хээрийн хэмжилт судалгаа, иргэдээс авах санал, материал боловсруулалт, төлөвлөгөөний төсөлд санал авах ажлыг гүйцэтгэж, ГЗБГЗЗЕГ-ын мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн санхүүжилтийн 60 хувийг олгоно. • Ажил бүрэн дуусаж ГЗБГЗЗЕГ-ын Архив мэдээллийн хэлтсийн баримт хүлээлгэн өгсөн актыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгоно.
15.	Ажлын онцгой нөхцөл	Орон нутгийн ба улсын тусгай хамгаалалттай газар ажиллах бол зөвшөөрөл авах.
16.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Төрийн болон албаны нууцын тухай хууль Монгол улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам
17.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:

ГЗБГЗЗЕГ-ЫН ГЗБХ-ИЙН ДАРГА Ц.ИХБАЯР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ГУХ-ИЙН ДАРГА Б.РЭНЦЭНДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

ГЗБГЗЗЕГ-ЫН ГЗБХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГХБХБГ-ИЙН ГУХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Т.САРАНЗУЛ